



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 05 сарын 03 одор

Дугаар 3/96

Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг батлах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндсэлэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Бага бүрэлдэхүүний бодлогын баримт бичиг"-ийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа М.Алтан-Очир/-т, шаардагдах хөрөнгийг тооцож, зохих төсөвт тусган зарцуулж ажиллахыг Санхүү, хангамжийн газар /хошууч Я.Ган-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.АМГАЛАНБАЯР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 45 дугаар сарын 22 –ны өдрийн 4 / 9 дугаар тушаалын хавсралт

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН
“БАГА БҮРЭЛДЭХҮҮНИЙ БОДЛОГО”-ЫН БАРИМТ БИЧИГ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бага бүрэлдэхүүний талаар баримтлах бодлого нь Төрийн албаны хууль, Цэргийн албаны хууль, Шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хүний нөөцийн зааварт үндэслэсэн үндсэн баримт бичиг мөн.

1.2 Энэхүү бодлогын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бага бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, сургах, нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах замаар үр дүнд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвортой суурьшилтай хүний нөөцийг бүрдүүлж байгууллагын тогтвортой хөгжил, чадавхийг бэхжүүлэхэд оршино

**Хоёр. Бага бүрэлдэхүүний бодлогод баримтлах
зарчим**

- 2.1 Захирах, захирагдах ес
- 2.2 Шударга ёс
- 2.3 Ил тод, тэгш байдал
- 2.4 Мерит тогтолцоо, мэргэшсэн тогтвортой байдал

**Гурав. Бага бүрэлдэхүүний бодлогод баримтлах
үндсэн чиглэл**

- 3.1 Бага бүрэлдэхүүний хүний нөөцийн бодлого
- 3.2 Бага бүрэлдэхүүний сургалтын бодлого
- 3.3 Нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах бодлого
- 3.4 Бага бүрэлдэхүүний төлөөллийн зөвлөл.

Дөрөв. Бага бүрэлдэхүүний хүний нөөцийн бодлого

4.1 “Бага бүрэлдэхүүний хүний нөөцийн бодлого” үндсэн чиглэл нь байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүний нөөцийг нээлттэй сонгон шалгаруулж, боловсролтой чадварлаг, эрүүл, ёс зүй, бие бялдарын өв тэгш хүний нөөцийг бүрдүүлж тогтвортой ажиллуулах бодлого баримтлана.

Энэ бодлогын хүрээнд

4.1.1 Байгууллагын зорилго зорилт, үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөвлөгөөнд үндэслэж хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөлтийг хийх.

- 4.1.2. Хүний нөөцийг шалгаруулан авах
- 4.1.3 Сургалтад хамруулах
- 4.1.4. Томилж, цэргийн цол олгох
- 4.1.5 Тангараг өргүүлэх

4.2 Бага бүрэлдэхүүнээс дараах шаардлага хангасан албан хаагчийг шалгаруулан мерит зарчмыг баримтлан офицерын бүрэлдэхүүнд оруулна. Үүнд:

4.2.1. Хувь хүний өөрийгөө хөгжүүлсэн байдал

- Томилогдоноос хойш боловсролын зэргээ ахиулсан байх
- Нэгээс доошгүй гадаад хэл сурсан байх
- Чөлөөт цагаа ашиглан бусад төрлийн сургалтад хамрагдсан байх /жолооны барилгын мэдээллийн технологийн гэх мэт/
- Спорт, урлагийн аль нэг төрлийг сонгон хичээллэсэн байх

4.2.2 Албан хаагчийн тухайн жилийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ /ур дүнгийн гэрээний биелэлтийг үнэлгээ/ А, В үнэлэгдсэн байх,

4.2.3 Ёс зүйн дүрэм зөрчөөгүй, сахилгын зөрчилгүй байх,

4.2.4 Тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан байх

4.3 Албан хаагчийг чөлөөлөх, халах тэтгэвэрт гаргах асуудлыг тагцхүү хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ

4.4 Бага бүрэлдэхүүний мэдээллийн санг бүрдүүлэн боловсруулалт, хурд, аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, шаардлагатай мэдээллийг түргэн шуурхай авах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, санхүүгийн төлөвлөлт хийх, хуульд нийцсэн шийдвэр гаргах, гүйцэтгэлийг хангахад мэдээллийн санг ашиглана.

Тав. Бага бүрэлдэхүүний сургалтын бодлого

5.1. “Бага бүрэлдэхүүний сургалтын бодлого” үндсэн чиглэл нь албан хаагчийн оюуны болон бие бялдарын чадвахийг бэхжүүлэх, сургалтын оновчтой тогтолцоог сонгон ашиглах туршлага судлах замаар хэрэгжүүлнэ

Энэ бодлогын хүрээнд

5.1.1. Байгууллагын онцлог үйл ажиллагааны чиглэл, хувь хүний боловсрол, мэдлэгийн түвшинг тогтоож сургалтын хэрэгцээг тодорхойлох

5.1.2 Сургалтын хэрэгцээг үндэслэн дунд хугацаанд /2 жил тутамд/ ахлагчийн бүрэлдэхүүнийг сургах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх /харилцааны соёл, эрх зүйн мэдлэг, бие хамгаалах урлаг г м чиглэлээр/

5.1.3 Гадаад дотоодын их дээд сургууль /бакалавр, магистр/-д суралцуулах

5.2 Гадаад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, туршлага солилцох

5.3 Байгууллагын дотоод нэгж хөсөнд туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна

Зургаа. Нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах бодлого

6.1. “Нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах бодлого” үндсэн чиглэл нь бага бүрэлдэхүүний ниймгийн асуудлыг шийдвэрлэхэд туслах. аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх эрсдлийг бууруулах замаар хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлогын хүрээнд:

- хууль, эрх зүйн орчинг сайжруулах
- ажлын байрны аюулгүй байдлыг хангах /хяналт тавих зориулалтын өрөөтэй болгох, эрүүл ахуйн болон хамгаалалтын тусгай хэрэгсэлээр хангах, ажил, амралтын цагийг баримтлах/
- даатгалд хамруулах
- цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох
- амьдралын нөхцөл байдлаа дээшлүүлэхээр хувийн орон сууц барих асуудал /Банк, санхүүгийн байгууллагатай хамтран/-д дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2 ШШГЕГ-ын даргын 2016 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан ШШГБ-ын алба хаагчдын ажиллах нөхцөл: нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх

6.3 Ажлын байрны орчин, албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцлийг сайжруулах асуудлыг үе шаттай төлөвлөж зохион байгуулах

6.4. Төв суурин газраас алслагдсан хорих анги, нэгжид ажиллаж байгаа бага бүрэлдэхүүний гэр бүлийг ажлын байраар хангах, үр хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах асуудалд дэмжлэг үзүүлэх

6.5. Төв, орон нутгийн анги, байгууллагууд албан хаагчдыг жил бүр эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт оруулж эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

6.6. Албан хаагчдыг жил бүр гэнэтийн ослын, эрүүл мэнд, амь насны болон бусад даатгалд даатгуулах

6.7 Бусад арга хэмжээ

Долоо. Бага бүрэлдэхүүний төлөөллийн зөвлөл

7.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, байгууллага нь бага бүрэлдэхүүний төлөөллийн зөвлөлтэй байх бөгөөд энэ нь “Ахлагчийн зөвлөл” /цаашид зөвлөл гэх/ байна.

7.2 Зөвлөл нь тухайн байгууллагын орон тооны хязгаараас хамаарч 5-8 хүний бүрэлдэхүүнтэй байж болно

7.3 Ахлагчийн зөвлөлийн гишүүн нь ШШГБ-д 3-аас доошгүй жил ажилласан ахлагч цолтой албан хаагчдаас бүрдэнэ

7.4. Зөвлөлийн дарга нь ахлагч бүрэлдэхүүний албан хаагч байх бөгөөд анги, байгууллагын даргын зөвлөлийн гишүүн байна.

7.5 Ахлагчийн зөвлөлийг тухайн нэгжийн даргын тушаалаар байгуулна.

7.6 Ахлагчийн зөвлөлийн ажиллах журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга батална

Найм. Бага бүрэлдэхүүний талаар баримтлах
бодлогын хэрэгжилт

8.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Захиргааны удирдлагын газар болон төв, орон нутгийн хорих анги, байгууллага нь энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.

---ООо---